

МОНГОЛ-ОРОСЫН ХУДАЛДААНЫ
ШИНЭ БОЛОМЖ

А.Даваасүрэн *

Товч утга

Монгол-Оросын худалдааны эргэлтийн бууралтад нөлөөлж буй хүчин зүйлс, манай улсын ОХУ руу нийлүүлж буй экспортын болон ОХУ-аас авч буй импортын барааны бүтэц, ОХУ ДХБ-ын гишүүнээр элсэн орсоноор манай хоёр улсын худалдаанд шинэ боломж нээгдэнэ.

Түлхүүр үг: Монгол Улс, ОХУ, БНХАУ, ДХБ, худалдаа, экспорт, импорт, нэн тааламжтай нөхцөл, гаалийн тариф

Монгол, Оросын хувьд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа нь олон жилийн түүхэн уламжлалтай билээ. 1990 он хүртэл Монгол улсын нийт гадаад худалдаанд Орос улс дийлэнх буюу 80 орчим хувийг эзэлж үлдэх хувийг тухайн үеийн социалист хамтын нөхөрлөлийн гишүүн орнууд эзлэж байв. Зах зээлийн шилжилтийн явцад хоёр орны хоорондох худалдаа, эдийн засгийн харилцааны цар хүрээ жил тутам улам хумигдах боллоо. Үүний хажуугаар Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн харилцаа улам өргөжин тэлсээр байна. Хүснэгт 1-ээс харна уу.

1990 онд Монгол улсын гадаад худалдааны эргэлт 1584,7 сая долларт хүрч байжээ. Үүнээс ОХУ-тай хийсэн худалдаа 1233,7 сая доллар болж манай улсын гадаад худалдааны нийт эргэлтийн 77,9 хувийг бүрдүүлж байсан бол 2000 онд 251,3 сая доллар буюу 79,6 хувиар огцом буурч энэ нь манай улсын гадаадын худалдааны нийт эргэлтийн 21,8 хувийг бүрдүүлэх болсон. Тэгвэл манай улсын ОХУ-тай хийсэн худалдааны бууралтын хоосон орон зайг БНХАУ эзлэх болсныг тэмдэглэх нь зүйтэй юм. Тухайлбал, 1990 онд манай улсын БНХАУ-тай хийсэн худалдааны эргэлт 33,6 сая доллар болж нийт худалдааны дөнгөж 2,1 хувийг эзлэж байсан бол 2000 онд

*А.Даваасүрэн – Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан доктор(Ph.D), профессор

Монгол-Оросын худалдааны шинэ боломж

400,1 сая доллар буюу бараг 12 дахин нэмэгдсэн байна.

Тэгвэл 2012 онд Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлт 11123,5 сая долларт хүрч, 2000 оныхтой харьцуулахад 9,6 дахин өссөн байна. Үүнээс ОХУ-тай хийсэн худалдаа 2012 оны урьдчилсан байдлаар 1928,0 сая долларт хүрч үүнийг 2000 оныхтой харьцуулахад 1676,7 сая доллароор буюу 7,6 дахин өссөн боловч манай улсын нийт худалдааны нийт эргэлтэд ОХУ-ын эзлэх хувийн жин 17,3 хувь болж буурсан байна.

Хүснэгт №1

Монгол-Оросын худалдааны эргэлтийн хэмжээ
(хувиар)

	Гадаад худалдааны нийт эргэлт	ОХУ-ын эзлэх хувь	Хятадын эзлэх хувь
2000	100	21.8	34.8
2001	100	22.0	30.4
2002	100	23.5	32.0
2003	100	21.8	34.4
2004	100	19.2	35.5
2005	100	19.9	36.7
2006	100	19.9	49.2
2007	100	20.0	52.1
2008	100	23.0	43.9
2009	100	20.9	48.0
2010	100	18.3	55.6
2011	100	15.1	56.6
2012	100	17.3	53.2

Эх үүсвэр: Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос гаргадаг жил тутмын статистикийн 2005-2012 оны эмхтгэлийн статистик тоо баримтад тулгуурлаж тооцов. www.nso.mn, www.1212.mn

Энэ байдлыг Хятадтай хийж байгаа худалдааны эргэлттэй жишиж үзэхэд 2012 онд Монгол-Хятадын худалдааны эргэлт 5921,7 сая долларт хүрч 2000 оныхоос 5521,6 сая доллароор буюу 14,8 дахин, 1990 оныхоос 176 дахин өссөж байна. 1990-2012 онд манай улсын гадаад худалдаанд БНХАУ-ын эзлэх хувийн жин 2,1-53,2 хувь хүртэл өссөн байна. Өөрөөр хэлбэл, Монгол-Оросын

худалдааны эргэлт буурч байхад Монгол-Хятадын худалдааны эргэлт өсөж, тэдгээрийн динамик өөрчлөлт нь эсрэг чиглэлтэй байна.

Дэлхийн эдийн засгийн хямрал хоёр улсын худалдаанд хэрхэн нөлөөлснийг авч үзвэл 2008 онд ОХУ-тай хийсэн худалдааны эргэлт 1328,6 сая долларт хүрч байсан бол дэлхийн эдийн засгийн хямралын улмаас 2009 онд 841 сая доллар болж 36,7 хувиар буурч 2010 оноос өсөж 1129,4 долларт хүрээд 2012 онд 1928,0 сая доллар болсон байна. Монгол-Оросын худалдааны эргэлтийн энэхүү өсөлт нь бараа, бүтээгдэхүүний биет хэмжээний биш зөвхөн үнийн өсөлт, импортын өсөлтийн үр дүнд бий болсон гэж үзэж болно.

Ийнхүү Монгол ОХУ хоорондын худалдааны эргэлтийн бууралтад дараах хүчин зүйлс нөлөөлсөн гэж ойлгож байна. Үүнд:

1. Хоёр улсын хооронд 1990 оноос өмнө тогтсон аж ахуйн болон үйлдвэрлэлийн хэлхээ холбоо, бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээ задарсан.

2. Хоёр орон хоёулаа бараа, бүтээгдэхүүний хомсдолд орж зах зээлээ нэн тэргүүнд шаардлагатай бараа бүтээгдэхүүнээр хангах зорилготой дэлхийн бусад орнуудтай гадаад худалдааг хийх болсон. Тухайлбал; ОХУ Баруун Европын улс орнуудтай, Монгол улс Ази, Номхон Далай, түүний дотор Зүүн Азийн улсуудтай худалдаа хийхэд гадаад худалдааны бодлого чиглүүлж гадаад зах зээл дээр худалдааны шинэ харилцагчтай холбоо тогтоох болсон.

3. 1990 оноос өмнө хоёр талын худалдааны төлбөр тооцоог шилжих рублээр хийж байсан бол зах зээлийн харилцаанд шилжихэд хоёр талын худалдааг гадаад хатуу валютаар хийж тогтолцоо руу шилжих болсон.

4. Хоёр улсын бараа, бүтээгдэхүүн өөрийн болон гадаад зах зээл дээр өрсөлдөх чадвараар сул байсан учир дотоод, гадаадын зах зээл дээр гадаадын түүний дотор хятадын хямд үнэтэй бараанд байр сууриа тавьж өгөхөд хүрсэн.

5. ОХУ-ын гадаад эдийн засгийн үйл ажиллагааг тарифын болон тарифын бус хатуу зохицуулалтыг хэрэгжүүлэх болж дотоод зах зээлээ хамгаалах, ялангуяа хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг онцгой хамгаалах бодлого хэрэгжүүлж эхэлсэн энэхүү бодлого зохицуулалтын хүрээнд манай улсын экспортын зарим бараа, бүтээгдэхүүн хамрагдах болсон.

6. Хоёр орны худалдааны төлбөр тооцоо шууд бус гуравдагч орны банкаар дамжин хийгдэж байгаа учир төлбөр удаашрах бэрхшээл тулгарч байна.

7. Хоёр улсын худалдаа зөвхөн ОХУ-ын Сибирийн холбооны бүсэд харъяалагддаг мужууд, хязгаар нутаг бүгд найрамдах улсуудтай хийх худалдаагаар хязгаарлагдах болсон.

8. ОХУ-ын гаалийн байгууллагын ажилтнуудын үйл ажиллагаанд хүнд суртал ихтэй гаалийн бүрдүүлэлтийн хугацаа маш удаан байдаг. Ялангуяа ачааны гаалийн бүрдүүлэлт ялимгүй зөрүүтэй байхад ачааг шууд хураан авдаг.

9. Хоёр улсын Засгийн газрууд тохиролцсон хил орчмын худалдааг дэмжих бодлогын хүрээнд хил орчмын иргэд харилцан бие бие рүүгээ визгүй иргэний үнэмлэхтэйгээ цагаан хуудсаар зорчих болсноор Монгол улсын Сэлэнгэ, Алтанбулгийн 200-300 иргэд, Хиагтын 50-100 гаруй иргэд жижиг ганзгын худалдаа эрхлэн Монголоос өргөн хэрэглээний бараа, хувцас, ОХУ-аас хүнсний бүтээгдэхүүн зөөж байна. Тэдний нэг даагийн хил дамнасан худалдааны барааны үнэ 200-500 долларын хэмжээнд хэлбэлзэж байна. ОХУ-ын хил дээр эдгээр монгол иргэдтэй оросын хил гаалийн ажилтнууд тэдэнтэй зүй бусаар харьцах, тэдний эрхийг зөрчих асуудал гарсаар удаж байна.

Монгол-Оросын худалдаа нь манай талд жил бүр алдагдалтай гарч байхад ОХУ-ын талд байнга ашигтай байдаг хандлагатай байна. Хэдийгээр манай хоёр улсын худалдааны эргэлт нийт дүнгээр жил тутам өсөн нэмэгдэж байгаа ч манай талын алдагдал өндөр хэвээр байна.

Манай улс ОХУ-д уул уурхай, олборлох салбарын түүхий эд (хайлуур жонш, зэсийн баяжмал), мах, махан бүтээгдэхүүн, оёмол, сүлжмэл эдлэл (тэмээ, ямааны ноосон, ноолууран бэлэн хувцас, бүтээгдэхүүн) экспортлож байна. Монгол улсын экспортыг зураг1-ээс харна уу.

Зураг1-ээс харахад 1990 онд манай улсын экспортод хуучнаар ЗХУ, одоогийн ОХУ 78,3 хувийг эзлэж байсан бол жил тутам буурч 2000 онд 8,4 хувь, 2012 онд 1,8 хувийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл манай улсын ОХУ-руу хийх экспорт үндсэндээ зогссон байна гэж дүгнэж болно. Үүнийг тээврийн өндөр зардал, оросын талын тарифын болон тарифын бус саад тотгор, Монголын мах, махан бүтээгдэхүүнд оросын талаас тавьж буй эрүүл ахуй хорио цээрийн дүрэм журамтай холбоотой бөгөөд нөгөө талаас, манай орны экспортын барааны өрсөлдөх чадвар сул байгаатай холбон



тайлбарлаж болно.

Эх үүсвэр: Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос гаргадаг жил тутамын статистикийн 2005-2012 оны эмхтгэлийн статистик тоо баримтад тулгуурлаж тооцов. www.nso.mn, www.1212.mn

Энэ байдлыг БНХАУ руу гаргасан экспорттой харьцуулахад 1990 онд манай улс экспортынхоо 1,7 хувийг тус улс руу гаргаж байсан бол 2000 онд 51,2 хувь, 2012 онд 92,6 хувийг гаргаж ОХУ-ын байрыг хэдийн эзэлсэн байна.

Ингэж манай улсын ОХУ руу нийлүүлж буй экспорт улам бүр буурч БНХАУ руу нийлүүлж буй экспорт нэмэгдэж, энэ хоёр улсуудын байр солигдоход дараах хүчин зүйлээс шалтгаалж байна гэж үзэж байна. Үүнд:

1. Дэлхийн бусад улс орнуудын бараа бүтээгдэхүүнтэй харьцуулахад манай улсын экспортын бараа, бүтээгдэхүүний боловсруулалтын болон чанарын түвшин доогуур, үнэ өндөр, барааны тоо хэмжээ, нэр төрөл цөөхөн.

2. Манай экспортын мал аж ахуйн түүхий эд болон мах, махан бүтээгдэхүүн ОХУ-ын эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангаж чаддаггүй.

3. Өмнөх нийгмийн үед манай улсын экспортын түүхий эдэд тулгуурлан ажиллаж байсан ОХУ-ын уул уурхайн болон боловсруулах үйлдвэрүүд зах зээлийн шинэ нөхцөлд түргэн дасан зохицож чадаагүйгээс болж ихэнх нь дампуурч зарим нь үйл ажиллагааныхаа чиглэлийг өөрчлөн худалдаа, үйлчилгээ, агуулахын чиглэлээр үйл ажиллагаа явуулах болсон учир манай түүхий эдийг худалдан авч боловсруулах шаардлагагүй болсон.

4. Оросын мах импортлогчид мах, махан бүтээгдэхүүнийг дараа төлбөрийн хэлбэрээр худалдан авдаг тул нийлүүлсэн махны төлбөрөө манай экспортлогчид олж авч чадахгүй байдал нилээд

Монгол-Оросын худалдааны шинэ боломж

гарч, тэд нийлүүлсэн махныхаа төлбөрийг олж авч чадахгүй алдах тохиолдол ихээхэн гарч байлаа.

5. Хятадын эдийн засгийн өндөр өсөлтийг дагаж аж үйлдвэрийн эрчимтэй хөгжлийн үр дүнд уул уурхай, олборлох салбарын болон мал аж ахуйн түүхий эдийн эрэлт өсөж, манай улсаас худалдан авах аливаа түүхий эдийг хилээр хориг саадгүй оруулах бодлого чиглэл барих болсон.

6. Монгол, Хятад улсуудын газар зүйн хувьд ойр дөт байршилт нь Хятадын зах зээл дээр манай улсын ямар ч түүхий эдийг маш хямд үнээр авах болсон гэх мэт.

1990 онд манай улс ОХУ-аас нийт импортын барааныхаа 77,5 хувийг авч дотоодын бараг бүх хэрэгцээг хангаж байлаа. Зах зээлд шилжиж эхэлсэнтэй холбоотой нэг талаас, манай улсын гадаад худалдааны харилцагчдын тоо өргөжин тэлж нөгөө талаас, дотоодын хэрэглэгчдийн хэрэглээний бүтцэд өөрчлөлт орж дэлхийн бараг бүх орноос импортоор бараа, бүтээгдэхүүн импортлох болсон нь ОХУ-аас авах импортыг бууруулах үндсэн нөхцөл болсон гэж үзэж байна. Гэсэн хэдий ч манай улсын дотоодын зах зээлд шаардлагатай бүх төрлийн бараа, бүтээгдэхүүний дотор ОХУ-ын экспорт өндөр хувийг эзэлсээр байна.



Эх үүсвэр: Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос гаргадаг жил тутамын статистикийн 2005-2012 оны эмхтгэлийн статистик тоо баримтад тулгуурлаж тооцов. www.nso.mn, www.1212.mn

ОХУ-аас авч буй манай улсын импортын бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрөл тийм ч олон биш бөгөөд энд нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн зонхилж байна. Манай улсад 2010 онд нийлүүлсэн ОХУ-ын экспортын бүтцэд бензин, дизелийн түлш 59,9 хувь, хөдөө аж ахуйн болон хүнсний бүтээгдэхүүн 25,0

гаруй хувь, гурил 3,0 хувийг эзэлж байсан бол 2011 онд нийт импортын 65,5 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлж 2010 оныхтой харьцуулахад 5,6 пунктээр нэмэгдсэн байна. Харин хүнсний улаан буудайн гурилын импортын хэмжээ 21,0 сая ам.долларт хүрч нийт импортын 1,3 хувийг эзэлж, өмнөх оныхоос 0,2 пунктээр өсч, улаан буудайн импортын хэмжээ 1,0 пунктээр буурсан байна. Энэ 2 төрлийн бүтээгдэхүүнийг манай улсын Засгийн газраас стратегийн бүтээгдэхүүнд хамруулсан бөгөөд ялангуяа нефтийн бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ, үнийн өөрчлөлт манай улсын эдийн засгийн тогтвортой байдалд тодорхой хэмжээгээр нөлөөлж ирсэн.

Харин ОХУ-аас импортоор авдаг цахилгаан эрчим хүчний үнийн дүнгээрээ сүүлийн 2 жилд огцом өссөн боловч нийт импортод эзлэх хувийн жин буурсан байна. Энэ байдлыг нэг талаас, ОХУ-аас нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний үнэ өссөн, нөгөө талаас, манай улсын эдийн засгийн таатай нөхцөл байдалтай уялдан эрчим хүчний хэрэглээ нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болно. Тухайлбал 2011 онд ОХУ-аас импортоор авсан цахилгаан эрчим хүч 16,5 сая ам.долларт хүрч өмнөх 2010 оныхоос 1,8 сая ам.доллороор буюу 12,2 хувиар нэмэгдсэн байна.

2011 оны байдлаар Монгол улсын стратегийн бүтээгдэхүүн болох бензин, дизелийн түлшний хэрэгцээний 94,4 хувь, гурилын хэрэгцээний 87,5 хувийг зөвхөн ОХУ-аас авч байгаа нь эдгээр төрлийн бүтээгдэхүүний хувьд тус улсаас хэт их хамааралтайг харуулж байна. ОХУ-ын нефтийн бүтээгдэхүүн тээвэрлэх төмөр замын тээврийн зардал өндөр, ОХУ-ын нефть бүтээгдэхүүнд оногдуулдаг экспортын гаалийн татвар өндөр, манай импортлогчид зөвхөн ганц монополь “Роснефть” компаниас нефтийн бүтээгдэхүүн худалдан авдаг ч гэсэн бид дотоодын өсөн нэмэгдэж байгаа хэрэглээгээ хангахын тулд ОХУ-аас импортоор газрын тосны бүтээгдэхүүн авахаас өөр аргагүй юм. Гэсэн хэдий ч бид энэ төрлийн бүтээгдэхүүний хамаарлыг багасгах зорилгоор Япон улсын тусламжтайгаар Дархан хотод газрын тос боловсруулах үйлдвэр барих талаар тохиролцож үйл ажиллагааг нь эхлүүлээд байна.

Ийнхүү 1990 оноос хойш манай хоёр орны эдийн засгийн хөгжил зах зээлийн зарчмаар явах болж худалдааны чиглэл нь өөрчлөгдөж, хамгийн зардал багатай, ашигтай, ирээдүйтэй, найдвартай, худалдан авах чадвартай гэсэн дэлхийн олон орнуудтай худалдааны хамтын ажиллагааг хөгжүүлэх болсон нь хоёр улсын өнөөгийн худалдааны байдлыг бодитоор харахад аль аль тал нь хэрэгтэй юм.

ОХУ ДХБ-ын хооронд 17 жил урт удаан үргэлжлүүлсэн ОХУ тус байгууллагын гишүүнээр элсэх хэлэлцээрт 2011 оны 11 сарын 11-нд цэг тавьж, 2012 оны 7 сарын эцэс гэхэд ОХУ протоколыг хэрэгжүүлэхээр болсон.


ОХУ гишүүнээр элссэн нь манай хоёр улсын хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд улмаар манай улсын эдийн засаг, түүн дотор үндэсний боловсруулах үйлдвэрүүдийн сэргэлтэд эерэг үр дүнг авч ирэх сайхан боломж бүрдэж байна гэж найдаж байна. Учир нь Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн харилцааг либералчлах, түүнд учирч буй бэрхшээлийг арилгах талаар хоёр улсын хооронд Засгийн газар хоорондын комиссын шугамаар олон удаагийн хэлэлцээр хийх явцад манай талаас “Зарим барааг хөнгөлөлттэй нөхцлөөр харилцан нийлүүлэх тухай” хэлэлцээрийг байгуулах саналыг оросын талд тавьсан боловч хэрэгжихгүй байсаар өдийг хүрчээ. Эдгээр хэлэлцээрийн явцад тохиролцсон асуудлаас зармыг нь дурьдвал: Монгол улс ДХБ-ын гишүүний хувьд Монгол улс ОХУ-тай 2005 онд Швейцар улсын Женевт хоёр талт хэлэлцээрт орох үед Монголоос ОХУ-д нийлүүлэх 100 гаруй барааны дундаж тарифыг 13 хувь байхаар тохиролцож гарын үсэг зурсан боловч ОХУ-ын импортын гаалийн тариф бууралгүй үлдсэн юм.

Тэгвэл ОХУ ДХБ-ын бүрэн эрхт гишүүнээр элсэн орсон нь манай хоёр улсын худалдаанд шинэ боломжийг нээгдэнэ гэж найдаж 2005 оны Женевт тохирсон тохиролцоог ажил хэрэг болгон хэрэгжүүлэх эрх зүйн шинэ орчин бүрдсэн тулд хоёр талын хэлэлцээрийг дахин үргэлжлүүлэх шаардлагатай гэсэн саналыг тавьж байна. Харин ОХУ-ын газрын тосны, түлш эрчим хүчний бүтээгдэхүүн болон хар өнгөт төмөрлөгийн хаягдал гэх мэт чухал түүхий эдийн экспортын татварыг бууруулахгүй байх тохиролцоо нь манайд нийлүүлэх газрын тосны бүтээгдэхүүний үнэ, хэмжээнд төдийлөн өөрчлөлт орно гэсэн найдлага бидэнд бага байна. Түүнчлэн ХАА-н барааны импортын дундаж тарифыг өөрчлөхгүй байхаар тохирсон нь одоо мөрдөж байгаа тариф хэвээрээ байх нээ гэж ойлгож байна. Дээрх хэлэлцээрүүдийн үеэр хөндөгдөлгүй хэвээрээ үлдсэн төмөр замын тариф, нэмэгдсэн өртгийн татварын хэмжээ, тарифийн бус хязгаарлалтуудыг анхаарах хэрэгтэй юм. Ийм тохиолдолд ОХУ ДХБ-ын гишүүнээр элссэн явдал нь хоёр орны худалдааны эргэлт болон манай экспортын хэмжээг огцом өсгөнө гэсэн найдлагыг багасгаж байна.

Гэвч ОХУ-ын импортын гаалийн татвар нь тухайн барааны боловсруулалтын түвшинг харгалзан тогтоодог. Тухайлбал, түүхий

эдэд 0-5 хувь, хагас боловсруулсан бүтээгдэхүүнд 5-15 хувь, бэлэн бүтээгдэхүүнд 15-аас дээш хувь байдаг. ОХУ Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн дагуу худалдааны нэн тааламжтай нөхцөл олгож байгаа хөгжиж байгаа орнуудаас гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татварын үндсэн тарифын 75 хувиар ногдуулдаг ба энэ ангилалд Монгол улс багтаж байна. Тэгвэл манай экспортын барааны код болон боловсруулалтын түвшингээс хамаарч 3,75-22,5 хувиар импортын татвар ногдуулж байгаа зэргийг тооцож үзэхэд манай улсын экспортын уламжлалт мал аж ахуйн гаралтай боловсруулах нэхмэл, сүлжмэл эдлэл, ноос, ноолууран бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүний экспортын татвар бага зэрэг буурч болох боловч үлдэж буй бусад төрлийн экспортын барааны хэмжээ болон импортын газрын тосны бүтээгдэхүүний импортын татварын хэмжээнд өөрчлөлт орохооргүй байна.

Ирээдүйд Монгол улсын ОХУ руу нийлүүлэх экспортын өсөлтийг оптимист ба пессимист хувилбараар 2020 он хүртэл таамаглал дэвшүүлснийг зураг 3-аас харна уу.



Эх үүсвэр: Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос гаргадаг жил тутамын статистикийн 2005-2012 оны эмхтгэлийн статистик тоо баримтад тулгуурлаж тооцов. www.nso.mn, www.1212.mn

Хэрэв бид 2005 онд ОХУ-тай тохирсон импортын гаалийн тарифийг дунджаар 13 хувь болгон бууруулах асуудлаа шийдүүлж чадвал манай улсын ОХУ руу нийлүүлэх экспортын хэмжээ 2012 оныг 2020 оныхтой харьцуулахад 2,2 дахин буюу жилд дунджаар 10-13 хувиар өсөх тооцоо гарч дунд болон урт хугацаанд сэргэх оптимист буюу өөдрөг байдал харагдаж байна.

Харин пессимист хувилбараар авч үзвэл хэрэв бид нэг талаас,

экспортынхоо бүтцийг сайжруулж, барааны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх талаар ямар нэгэн арга хэмжээ авахгүй, нөгөө талаас, экспортынхоо бараанд ОХУ-аас тавьж байгаа янз бүрийн хориг саадыг арилгах талаар хэлэлцээрийг шинээр эхлүүлж ямар нэгэн тохиролцоонд хүрч чадахгүй бол манай экспортын хэмжээ 2020 он гэхэд дөнгөж 19,6 хувиар нэмэгдэж одоогийн түвшингээс төдийлөн өсөхгүй байдал харагдаж байна.

Гэсэн хэдий ч дээрх асуудлыг шийдэхэд бидэнд өөрсдөөс шалтгаалах өргөн боломжууд байгаа бөгөөд үүний тулд нэн тэргүүнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж бид үзэж байна. Үүнд:

1. Экспортын барааны чанар, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэгж барааны өөрийн өртгийг бууруулах, нэр төрлийг олшруулах зорилгоор гадаадын дэвшилтэд технологийг ашиглахад бүх талаар дэмжлэг туслалцааг үзүүлэх
2. Экспортын мах, махан бүтээгдэхүүний дараа төлбөрийн хэлбэрийг өөрчилж аккредитив төлбөрийн хэлбэрт шилжүүлэх
3. Малчдад малаа эрүүлжүүлэх, вакцинжуулах, ашиг шим өндөртэй товарлаг мал аж ахуй өсгөн үржүүлэх сонирхлыг төрүүлж урамшуулал олгож, санхүүгийн дэмжлэг үзүүлэх
4. Монгол улсын эрүүл ахуйн дүрэм журмыг ОХУ-ын болон хүнсний эрүүл ахуйн стандарттай нийцүүлэх талаар зохих арга хэмжээг авах
5. Мал аж ахуйн түүхий эд боловсруулах болон хүнсний үйлдвэрүүдэд санхүүгийн дэмжлэг дотацийг нэмэгдүүлэх
6. Үндэсний боловсруулах үйлдвэрүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг ороход төрийн бодлогоор дэмжлэг үзүүлж орлогын татварын болон гаалийн татварын хөнгөлөлт үзүүлэх
7. “Газрын тосны бүтээгдэхүүн бол Монгол Улсын стратегийн бүтээгдэхүүн” гэсэн утгаар боловсруулах үйлдвэрийг барих асуудлыг төр, засаг өөрийн мэдэлд авч хувийн хэвшилтэй хамтран холимог өмчтэйгээр байгуулахыг нэн яаралтай шийдвэрлэх
8. Уул уурхайн олборлох салбарт хэрэгжихээр зэхэж буй томоохон төслүүдэд ОХУ-ын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулж, дэд бүтцийг барьж байгуулах, Сайн-шандын аж үйлдвэрийн паркыг барихад хамтран ажиллах, өмнөх олон жилийн туршлагаа харгалзан уул уурхайн түүхий эд

боловсруулах хамтарсан үйлдвэрийг барьж байгуулах
Ингэснээр манай улсын экспортын бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин дээшилж чанар сайжирч, барааны тоо хэмжээ, нэр төрөл олширч зөвхөн ОХУ биш гадаад улсуудын зах зээл дээр өрсөлдөх чадвар дээшилнэ гэж үзэж байна. ОХУ-тай ДХБ-ын хүрээнд шинэ нөхцөл байдалд хэлэлцээрийг сэргээн үргэлжлүүлэх шаардлага нь манай хоёр улсын хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлж улмаар хоёр орны олон жилийн өмнө байсан уламжлалт, найрамдалт, бүх талын сайхан харилцаа шинэ түвшинд сэргэж, үүний үр шимийг хоёр орны ард иргэд ялангуяа ОХУ-ын Сибирийн иргэд хүртэх болно. Монгол Улс, ОХУ-ын хувьд бие биендээ газар нутаг, хил, хэл соёлын хувьд ямар нэгэн маргалдах, зөрчилдөх асуудал байхгүй бөгөөд Монгол улс өөрийн эдийн засгийн багтаамж, хүчин чадал, экспортын хэмжээгээр ОХУ-ын эдийн засгийн аюулгүй байдалд аюул учруулахуйц хэмжээний бусад томоохон орнуудтай харьцуулахад маш өчүүхэн гэдгийг энд зориуд цохон тэмдэглэх нь зүйтэй юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Закон Российской Федерации “О таможенном тарифе” 21 мая 1993г №5003-1, www.ZakonRus.ru
2. Дюмулен И.И. Всемирная Торговая Организация. Монография. М., 1994 г.
3. ОХУ-ын Эрхүү хотын Байгалийн эдийн засаг, эрх зүйн улсын их сургуулийн “Татвар, гаалийн удирдлагын” тэнхмээс 2011оны 4-р сарын 19-нд зохион явуулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал дээр ОХУ-ын Эрхүү хотын Байгалийн эдийн засаг, эрх зүйн улсын их сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, доктор, профессор, ОХУ-ын шинжлэх ухааны гавьяат ажилтан Самаруха Виктор Ивановичийн тавьсан “К вопросу о вступлении России в ВТО” илтгэл
4. ОХУ-ын “Эксперт” сэтгүүлийн 2006 оны №41 (535)
5. Германий Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн (ГТХАН) санхүүжилтээр хэрэгжиж буй Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого” төслийн № G/21/04 хүрээнд Монгол-Оросын худалдаан дахь тарифын бус саад тотгор, стандартуудын талаархи судалгааны дүн шинжилгээ, 2005 оны 12 сар.
6. Монгол Улсын Гаалийн Ерөнхий газрын гадаад худалдааны статистикийн эмхтгэл 1999-2011он. www.ecustoms.mn

7. Үндэсний статистикийн хорооноос гаргадаг жил тутамын статистикийн эмхтгэл 2005-2012. www.nso.mn, www.1212.mn

Abstract

The factors influencing the reduction of trade between Mongolia and Russia, structure of Mongolia's exports to Russia, Mongolia's imports from Russia, the new challenges Mongolian and Russian trade relations after Russian joins to the WTO.

Keywords: Mongolia, Russia, China, the WTO, trade, exports, imports, regime of most-favored-nation, customs tariffs, etc.